



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/384

Булган сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний  
хугацаа сунгах тухай**

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын хөгжлийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Н.Ганзориг (ГЭ84092111)-ийн Булган сум 5 дугаар баг Агуулахын товог 2 дугаар гудамж 204а тоотод байршилтай 6308002479 нэгж талбар бүхий гэр, орон сууцны хашааны зориулалтаар эзэмшиж буй 40 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 7 жилээр, Х.Байгаль (ГЮ69082065)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 12 дугаар гудамж 1209 тоотод байршилтай 6308008204 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 937 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр, Орхон аймаг дахь нефть хангамжийн салбар Булган-1 шатахуун түгээх станц (РД:2075261)-ын эзэмшиж буй Булган сум 6 дугаар баг Залуус 10 дугаар гудамж 1000 тоотод байршилтай 6308003449 нэгж талбар бүхий 4670 м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 5 жилээр тус тус сунгасугай.

2. Н.Ганзориг, Х.Байгаль Орхон аймаг дахь нефть хангамжийн салбар Булган-1 шатахуун түгээх станц нарт Булган сумын шинэчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулахыг танилцуулж, газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн Н.Ганзориг, Х.Байгаль, Булган-1 шатахуун түгээх станцад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

